



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/34

Хэрлэн сум

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлиг бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн үйл ажиллагааг явуулахыг зөвлөлийн орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Батлагдсан журмын дагуу хилийн сумдад Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл (ХХТХСЗ)-ийг байгуулан, хилийн цэргийн салбаруудтай нягт хамтран ажиллахыг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдын Засаг дарга нарт даалгасугай.


4.Аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл (ХХТХЗ), хилийн сумдын Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл (ХХТХСЗ)-д захирамжийг хүргэн үүрэг даалгавраар хангаж, мэргэжлийн удирдлага арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Зөвлөлийн орлогч дарга, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн захирагч (хурандаа П.Мөнхбаатар), зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/41 захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын  
2024 оны 01 дүгээр сарын 25-ны  
А/34 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ХХТХ-ний зөвлөлийн  
дарга

Хэнтий аймгийн Засаг дарга

ХХТХ-ний зөвлөлийн орлогч  
дарга

Хилийн 0287 дугаар ангийн захирагч,  
Хэнтийн хэсгийн Хилийн бүрэн эрхт  
төлөөлөгч

ХХТХ-ний зөвлөлийн нарийн бичгийн  
дарга

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын  
газрын дарга

ХХТХ-ний зөвлөлийн гишүүд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
дарга  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
дарга  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга  
Хөгжлийн бодлого төлөвлөлт,  
хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга  
Цэргийн штабын дарга  
Давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч  
Хэнтий аймгийн Прокурорын газрын ерөнхий  
прокурор  
Тагнуулын ерөнхий газрын Хэнтий аймаг  
дахь Тагнуулын хэлтсийн дарга  
Цагдаагийн газрын дарга  
Онцгой байдлын газрын дарга,  
Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэх газар -419 дүгээр нээлттэй хорих  
ангийн захирагч  
Дотоодын цэргийн 830 дугаар тусгай  
салбарын захирагч  
Эрүүл мэндийн газрын дарга  
Орон нутгийн өмчийн газрын дарга  
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
дарга  
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга  
Мэдээлэл, холбоо, сүлжээний газрын дарга

Цахилгаан холбооны газрын дарга

Хилийн 0287 дугаар ангийн Захирагчийн I  
орлогч, штабын дарга

ХХТХСЗ-ийн дарга, Дадал сумын Засаг  
дарга

ХХТХСЗ-ийн дарга, Биндэр сумын Засаг  
дарга

ХХТХСЗ-ийн дарга, Батширээт сумын Засаг  
дарга

ХХТХСЗ-ийн дарга, Өмнөдэлгэр сумын Засаг  
дарга

-oOo-





Аймгийн Засаг даргын  
оны 01 дүгээр сарын 25-ны  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

## ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нийтлэг үндэслэл

#### Нэг. Зөвлөлийн зорилго

1.1 Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл нь улсын хил орчмын нутаг дэвсгэрт хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад оролцоно.

1.2 Улсын хил хамгаалалтад туслах хүчнийг хилийн аймаг, сум, багийн төв, хилийн цэргийн анги, салбар, суурин газар болон шаардлагатай бусад газарт улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

1.3 Хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг улсын хил хамгаалалтад туслах хүчний гишүүнээр бүртгэхдээ түүний бичгээр гаргасан хүсэлт, улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймаг, сумын туслах хүчний зөвлөлөөр хэлэлцэж, Засаг даргын захирамжаар батална.

#### Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1 Улсын хил хамгаалалтад туслах хүчнийг аймаг, сумын Засаг дарга, түүний дэргэдэх зөвлөл, улсын хил хамгаалах байгууллага тус тусын бүрэн эрхийн хүрээнд удирдлагаар хангана.

2.2 Зөвлөлийн дарга нь аймаг, сумын Засаг дарга, түүний орлогч дарга нь хилийн цэргийн ангийн дарга, нарийн бичгийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.

#### Гурав. Зөвлөл нь дараахь бүрэн эрхтэй:

3.1 Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлж, Монгол Улсын хилийн хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага сахин биелүүлж байгаад хяналт тавих;

3.2 Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.2 Иргэнийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад татан оролцуулах;

3.3 Иргэдийг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь улсын хил хамгаалалтад туслах хүчин болгон зохион байгуулж, хил хамгаалалтад оролцуулах;

3.4 Хилийн аймаг сумын төсөвт улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардал тусгах.

**3.5** Улсын хил хамгаалах байгууллага, хилийн аймаг, сумын улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл нь хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүнд урамшуулал олгож, шагналд тодорхойлж болно.

**Дөрөв. Зөвлөл нь дараахь үүргийг хүлээнэ:**

**4.1** Нутаг дэвсгэртээ байгаа улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн хил хамгаалалтад тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

**4.2** Улсын хил хамгаалах байгууллагатай хамтран туслах хүчнийг хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулах;

**4.3** Улсын хил хамгаалалтад төсөвлөсөн зардлын зарцуулалтад хяналт тавих;

**4.4** Улсын хилийн зурвас, бүсэд улсын хил хамгаалах байгууллагын зохих зөвшөөрөлтэйгөөр ажил, үйлдвэрлэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулах;

**4.5** Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг санаатай буюу давтан зөрчсөн Монгол Улсын иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

**4.6** Улсын хил хамгаалалтад идэвх зүтгэлтэй ажилласан, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг удаа дараа илрүүлсэн туслах хүчний гишүүнийг шагнаж урамшуулах, шагналд тодорхойлох, зөрчил гаргасан гишүүнийг туслах хүчний бүрэлдэхүүнээс хасах арга хэмжээ авах;